

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа. Энэхүү уналт нь АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээр ахицгүй байгаатай холбоотой.

S&P 500 индексийн сагсанд багтах эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа газрын тосны үнэ өссөнтэй холбоотой хамгийн их өсөлттэй байсан ба эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцаанууд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Элизабет Уорренийн өөрийн нийгмийн даатгалын бодлогыг танилцуулсантай холбоотой мөн өсөлттэй байлаа.

Өргөн хэрэглээний бус бараа бүтээгдүүний худалдаа эрхэлдэг компаниудын хувьцааны ханш Macy's, Home Depot, Kohl's болон бусад компаниудын борлуулалтын хэмжээ хүлээлтээс доогуур байсантай холбоотой уналттай байсан бол Target компанийн борлуулалт болон ашигт ажиллагаа хүлээлтийг давсантай холбоотой хувьцааны ханш нь өсөлттэй байв.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээр ахицгүй байгаагаас үүдэн уналттай байсан ч FTSE 100 индекс фунтийн ханш суларсантай холбоотой өсөлт үзүүлээ.

Евро бүсийн үйлдвэрлэлийн идэвх 11-р сард өмнөх саруудтай харьцуулахад бага хэмжээгээр буурсан ч үйлчилгээний салбар суларч эхлэв. Евро бүсийн үйлдвэрлэлийн идэвхийн индекс сүүлийн 3 сарын дээд төвшинд хүрсэн ч бууралтыг илтгэх бүсэд байсаар байна. Харин ХБНГУ-ын үйлдвэрлэлийн индекс 2 сар дараалан өсөлттэй байлаа.

Их Британи улсын хувийн салбарын идэвх сүүлийн 3 жилийн хамгийн өндөр хэмжээгээр буусан ба Их Британи улсын эдийн засгийн 80%-ийг бүрдүүлдэг үйлчилгээний салбар мөн суларсан байна.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа.

The Financial Times-аас Япон улсын төв банкнаас дотоодын хувьцаа эзэмших биржид арилжаалагдах сангуудаас худалдан авалт хийгээгүй 40 өдөр болсон байгааг нийтлэжээ.

Шинжээчдийн үзэж байгаагаар энэ онд Японы төв банкнаас 5 их наяд иений худалдан авалт хийх ёстой байсан бол өмнөх оны мөн үеэс эхлэн 3.8 их наяд иений худалдан авалт хийсэн байгаа юм.

БНХАУ: АНУ-аас Хонг Конгийн эсэргүүцлийг дэмжсэн хууль баталсан нь хоёр тал худалдааны хэлэлцээр хийх боломжгүй болгоно гэсэн хүлээлтээс хамааран БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа.

БНХАУ-ын эрх баригчид энэ долоо хоногт хүүний төвшинг бууруулсан ба шинжээчдийн үзэж байгаагаар АНУ болон БНХАУ-ын худалдааны маргаан үргэлжлэх төлөвтэй ба хүү бууруулсан нь худалдааны маргааны эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,571.65	-1.37% ▼
Dow Jones	АНУ	27,875.62	-0.46% ▼
S&P 500	АНУ	3,110.29	-0.33% ▼
Nasdaq	АНУ	8,519.88	-0.25% ▼
S&P/TSX	Канад	16,954.84	-0.43% ▼
FTSE 100	Их Британи	7,326.81	0.33% ▲
S&P/ASX 200	Австрали	6,709.80	-1.23% ▼
Nikkei 225	Япон	23,112.88	-0.82% ▼
Hang Seng	Хонг Конг	26,595.08	1.02% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.04
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.98
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.00
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.50
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.47
DBM' 2023	USD	7.250%	105.75
TDBM' 2020	USD	9.375%	102.51
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.53

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.700	-0.03 ▼
Libor 3M	1.900	0.00
Libor 6M	1.910	-0.01 ▼
Libor 1YR	1.940	-0.02 ▼
US 2YR Bond	1.626	0.02 ▲
US 3YR Bond	1.614	0.01 ▲
US 5YR Bond	1.629	-0.01 ▼
US 10YR Bond	1.765	-0.06 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.11.22	Өөрчлөлт
USD	2,706.68	1.31% ▲
CNY	384.77	1.94% ▲
EUR	2,994.94	1.72% ▲
RUB	42.48	2.19% ▲
KRW	2.30	2.22% ▲
JPY	24.92	1.05% ▲
CAD	2,038.32	0.91% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,461.93	-0.43% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	17.02	0.35% ▲
Зэс	USD/lb.	265.90	0.28% ▲
Нүүрс	USD/MT	73.02	2.27% ▲
WTI газрын тос	USD/bbl.	57.77	0.09% ▲
Brent газрын тос	USD/bbl.	63.39	0.14% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. X	7.60%
Бодлогын хүү	2019. X	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. X	11.06%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. X	11.48%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. X	4.82%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. X	16.90%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. X	10.61%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 49 компанийн 5,880.2 сая төгрөгийн 2,478,944 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Улсын их дэлгүүр” /UYD/ компанийн хувьцаа 35.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,350.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Дархан нэхий” /NEH/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 1,200.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

11-р сарын 22-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,527.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,571.65 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.37%-аар буурсан байна.



Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	5,880.2
Зах зээлийн үнэлгээ	2,527,590.0

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,571.65	-1.37% ▼
MSE I индекс	8,681.99	-0.71% ▼
MSE II индекс	7,726.80	1.39% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
МИК Холдинг	356,113	4,052,568,490
Инвескор ББСБ	586,523	1,202,454,511
Мандал даатгал	35,515	177,180,271
Ард санхүүгийн нэгдэл	66,989	114,319,140
Могойн гол	6,884	61,956,000

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Улсын их дэлгүүр	1,350.00	35.00% ▲
Женко тур бюро	74.00	14.64% ▲
Хасу-Мандал	6,490.00	14.06% ▲
Түмэн шувуут	153.99	5.12% ▲
Ремикон	31.46	4.76% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дархан нэхий	1,200.00	-15.00% ▼
Хөсөг трейд	1,950.00	-10.80% ▼
Махимпекс	2,200.00	-10.39% ▼
Стандарт проперти групп	70.00	-10.26% ▼
Монгол шуудан	570.00	-5.00% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ти Ди Би Капитал	5,301,728,901
Ард Капитал Групп	4,059,730,116
Инвескори Капитал	1,201,566,081
Би Ди Сек	299,062,698
Ард Секюритиз	244,916,505

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	566.70	603,072
Таван толгой	6,500.00	342,324
МИК Холдинг	12,230.00	253,275
Говь	258.38	201,565
Инвескор ББСБ	2,150.00	154,215

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.21-нд олгов
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.18-нд олгов
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.10.24-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан тамгаа гардаж, үүрэгт ажилдаа орлоо

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11-р сарын 22-ны өдрийн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны даргаар Д.Баярсайханыг томиллоо.

Ажил хүлээлцэхэд УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалан, УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга Б.Чойжилсүрэн, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөх Ц.Мөнхбаяр болон Хорооны газар, хэлтсийн дарга нар байлцав.

Мөн УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалан, УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга Б.Чойжилсүрэн нар СЗХ-ны даргын ажилд амжилт хүсэж, Монгол Улсаа “Саарал жагсаалт”-аас хурдан гаргахын тулд анхаарч ажиллахыг зөвлөлөө.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан 1997 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг төгсөж, 2004 АНУ-ын Индианагийн их сургуульд Төрийн санхүүгийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан.

Тэрбээр 1998 онд Сангийн яамны Бүтцийн өөрчлөлт, өмчийн хэлтэст мэргэжилтэн, 2006 онд Дэлхийн банкны “Тогтвортой амьжиргаа” төслийн зохицуулагч, 2010 онд СЗХ-ны дэргэдэх Бичил санхүүгийн орон тооны бус бодлогын зөвлөлийн гишүүн, 2012 онд Бичил санхүүгийн хөгжлийн сангийн гүйцэтгэх захирал, 2016 оноос СЗХ-ны Орон тооны гишүүн бөгөөд дэд даргаар ажилласан.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Санхүүгийн зохицуулах хорооноос “Улсын их дэлгүүр” ХК-ийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хийгдэж буй зарим арга хэмжээний талаар

Санхүүгийн зохицуулах хороо нь “УИД” ХК-ийн 45,000 орчим жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тус компанийн эрх бүхий албан тушаалтнуудын “УИД” ХК-ийн барилгыг гаднах талбайн хамт бүхэлд нь “Номин реалтор” ХХК-д түрээсэлсэн үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээнүүдийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцуулж, компанид учруулсан 4.4 тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулах, мөн Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлээгүйн улмаас 2017 оны 4-р сараас 2018 оны 12-р сарыг дуустал хугацаанд компанид учруулсан 428.6 сая төгрөгийн хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнуудаар гаргуулахаар 2019 оны 11-р сарын 01-ний өдөр Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд Санхүүгийн зохицуулах хорооны дарга нэхэмжлэл гаргалаа.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

“Инвектор ББСБ” ХК-ийн багцын арилжаа явагдлаа

2019 оны 11-р сарын 22-ны өдөр “Инвектор ББСБ” ХК-ийн /MSE:INV/ багцын арилжаа явагдлаа. Багцын арилжаагаар тус компанийн 584,116 ширхэг хувьцаа 1.2 тэрбум төгрөгөөр арилжигджээ.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

“Мик холдинг” ХК-ийн багцын арилжаа явагдлаа

2019 оны 11-р сарын 22-ны өдөр “МИК Холдинг” ХК-ийн /MSE:MIK/ багцын арилжаа явагдлаа. Багцын арилжаагаар тус компанийн 356,110 ширхэг хувьцаа 4.1 тэрбум төгрөгөөр арилжигджээ.

“Мик холдинг” ХК-ийн /MSE:MIK/ хувьд 2019 он гарснаас хойш хийгдэж буй 3 дахь багцын арилжаа бөгөөд үүнээс өмнө 7-р сард 2 удаагийн арилжаагаар 14.3 тэрбум төгрөгийн багц хувьцаа арилжигдаж байсан юм.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

Хорооны 2019 оны XVI хуралдаан болов

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны XVI хуралдаан болж нийт 31 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хуралдаанаар “Нийслэлийн өмчит Улаанбаатар” ХХК, “Эрдэнэс ассет менежмент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, “Хөвсгөл алтан дуулга” болон “Лэндмн ББСБ” ХК-иудын хаалттай хүрээнд гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэв.

Мөн “Мандал даатгал” ХК-ийн хувьцаа хуваах асуудлыг шийдвэрлэж, “Очун капитал” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэж, нэр бүхий 3 компанийн хувьцааг тусгаарлалтаас чөлөөлж, нэг компанийн үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хаслаа.

Түүнчлэн зарим даатгалын компанийн давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа, төлөөлөгчийн газар, даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэж, нэр бүхий компаниудын даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, салбарыг нь бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэв.

Мөн нэр бүхий үнэт цаасны компани, хадгаламж зээлийн хоршоо, ББСБ-уудын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг сунгах, зөвшөөрөл нэмж олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

МХБ 2019 оны 11-р сарын 25-ны өдөр ажиллаж, 26, 27-ны өдрүүдэд амрав

Монголын хөрөнгийн бирж нь 11-р сарын 25-нд буюу Даваа гарагт хэвийн хуваарийн дагуу ажиллаж, 11-р сарын 26-ны Мягмар гарагт “Улс тунхагласны баяр”, 27-ны Лхагва гарагт “Чингис хааны мэндэлсэн өдөр” тус тус тохиож байгаатай холбогдуулан ажиллаагүй ба 11-р сарын 28-ны Пүрэв гаргаас эхлэн хэвийн хуваариар ажиллана.

х сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

УИХ: Оюутолгойн гэрээг сайжруулах тогтоолын төслийг баталлаа

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээ болон бусад гэрээг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах тухай тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа. УИХ-ын Ажлын хэсгийн боловсруулсан “Оюутолгойн ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” уг тогтоолын төсөл батлагдсанаар “Рио Тинто”-той ширээний ард сууж хэлэлцээр хийх ажилд томоохон алхам боллоо. Уг батлагдсан тогтоолд найман чиглэлийг тусгасан бөгөөд төсөл дэх Засгийн газрын эзэмшлийг нэмэлт роялти руу шилжүүлэх хувилбарыг судлах асуудал орсон нь анхаарал татаж байна. Учир нь Засгийн газар төсөл дэх 34%-ийн эзэмшлээ зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж буй. Уг зээл нь 6.5% дээр нэмэх нь LIBOR нөхцөлтэй буюу бараг 10%-ийн хүүтэй учир 2041 он хүртэл Монголын тал эзэмшлийн хувиасаа ямар ч ногдол ашиг хүртэхгүй гэсэн судалгааг УИХ-ын Ажлын хэсэг танилцуулаад байгаа юм.

Мөн уг тогтоолын төсөлд Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээг сайжруулах, Дубайн гэрээг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэх, төслөөс Монголд оногдох өгөөжийг ТЭЗҮ-д тусгасан 53%-аас бууруулахгүй байх, ус ашиглах нөхцөлийг тогтоох, ордын нөөцийн үнэлгээг хийх зэрэг олон асуудлыг хамарсан байна.

УИХ-ын гишүүд төслийг зогсоох бус гагцхүү Монголын талд оногдох өгөөжийг нэмэгдүүлэх хэрэгтэйг онцолж байна. Гэхдээ Засгийн газар тогтоолд тусгасан чиглэлийн дагуу ажлуудаа эмхэлж “Рио Тинто”-той ширээний ард суух хүртэл багагүй хугацаа шаардагдах магадлалтай юм. Тэр хэрээр Оюутолгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалтын эргэн тойрон дахь тодорхойгүй уур амьсгал үргэлжлэх эрсдэлтэй байна.

“Рио Тинто” Оюутолгой төслийн зардал 1.2-1.9 тэрбум ам.доллараар нэмэгдэж, ашиглалтад орох хугацаа хойшлохоор байгааг өнгөрсөн долдугаар сард мэдээлсэн. Уг шаардлагатай нэмэлт санхүүжилт татах асуудал нь Монголын Засгийн газартай Рио Тинто хэрхэн ойлголцож, хэлэлцээрт хүрэхээс шууд хамаарах юм.

Тогтоолын төсөлд:

-Засгийн газар, “Рио Тинто интернейшнл холдинг” болон “Айвенхоу Майнз” компанийн 2009 оны аравдугаар сард байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, 2011 онд байгуулсан “Эрдэнэс Монгол”, “Айвенхоу Оюутолгой”, “Оюутолгой Нидерланд Би Ви”, “Оюу Толгой” компанийн Хувь нийлүүлэгчдийн гэрээг УИХ-ын 2008 оны “Үндсэн зарчим, удирдамж батлах тухай” тогтоол, 2009 оны “Оюутолгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай” тогтоол болон Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд сайжруулах цогц арга хэмжээ авах, энэ чиглэлд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус зөвлөх үйлчилгээ авахыг даалгаж буй юм.

-Засгийн газар, “Оюутолгой”, “Ресурс Лимитед”, “Ти Эйч Ар Оюутолгой”, “Оюутолгой Нидерланд”, “Рио Тинто интернейшнл холдинг” компанийн 2015 онд байгуулсан Оюутолгой төслийн Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөөг Монгол Улсын эрх ашиг, хууль, тогтоомжид нийцүүлэн сайжруулах,

-Оюутолгой төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг хөрөнгө оруулалтын гэрээ болон 2010 оны ТЭЗҮ-ийн тооцоололд зааснаар 53%-аас бууруулахгүй байх хүрээнд Монголын талын 34%-ийн хувьцааг бүтээгдэхүүн хуваах нөхцөл, эсхүл АМНАТ-т оруулах хувилбарыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулан УИХ-д танилцуулах,

-Оюутолгойн ордын зэс, алт, мөнгө болон бусад дагалдах элементийн нөөцийн үнэлгээг Монгол Улсад мөрдөж буй олон улсын стандартын дагуу дахин хийж, үүнд үндэслэсэн ТЭЗҮ-ийг дахин боловсруулж, эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулах,

-Байгаль орчны болон усны нөхцөл байдлын үнэлгээг Говийн бүсийн гүний ус ашиглах нөхцөлийг харгалзан тогтоох,

-УИХ-ын даргын захирамжаар байгуулсан Оюутолгой ордыг ашиглах, хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгах ажлын багийн санал, дүгнэлтийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авах,

-Оюутолгой төслийн Монголын талын төлөөллийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүү болон хүний нөөцийн чадавхыг олон улсын түвшинд хүргэж бэхжүүлэх,

-Уг тогтоолын хэрэгжилтийг хангахыг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд хоёрдугаар зүйлээр үүрэг болгох тухай тусгасан юм.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.